



Долоо хоног тутмын хэвлэл
2015 оны 12 дугаар сарын 25
№48 /909/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

2138

**Төрийн болон орон нутгийн
өмчийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай**

**Монгол Улсын Их
Хурлын тогтоол**

2141

**Монгол Улсын 2016 оны
төсвийн тухай хууль
баталсантай холбогдуулан
авах зарим арга хэмжээний
тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

2147

**Гадаадаас 2016 онд авах
ажиллах хүч, мэргэжилтний
эзлэх хувийг тогтоох тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

571.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2137
572.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2138
573.	Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2140
574.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2140

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

575.	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 108	2141
576.	Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 15 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 110	2145

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

577.	Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 183	2146
------	---	------------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

578.	Гадаадаас 2016 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай	Дугаар 432	2147
579.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 441	2152

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА,
НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.в, 29 дүгээр зүйлийн 29.1.1.д дэх дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 11 дүгээр
сарын 26-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН
ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/21¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй тухайн хуулийн этгээдийн зорилтын саналын талаар жил бүрийн 03 дугаар сарын 25-ны дотор тохиролцоно.”

2/65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчилсан тухай бүр хувьчлалыг эрхлэн явуулсан этгээд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна. Тайлан бичих загварыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн гарчиг, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “итгэмжлэгдсэн” гэсний өмнөх, 45 дугаар зүйлийн “Төрийн өмчийн хорооны” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын” гэж, 11 дүгээр зүйлийн “Төрийн өмчийн хороо дараахь бүрэн эрхтэй” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах бүрэн эрхтэй” гэж, 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “Төрийн өмчийн хороо” гэснийг “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 18 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 36 дугаар



зүйлийн 1 дэх хэсэг, 38 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 45 дугаар зүйл, 46 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, 57 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 65² дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 65³ дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 65⁴ дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 65⁵ дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 70 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 72 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Төрийн өмчийн хороо” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт, 21¹ дүгээр зүйлийн 1, 10 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын “Төрийн өмчийн хороонд” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад” гэж, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт, 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “хөрөнгийг” гэснийг дараах, мөн зүйлийн 4 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 1, 3, 5 дахь хэсэг, 50 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт, 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, мөн зүйлийн 4 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчийн хорооны” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын” гэж, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтын “Төрийн өмчийн хороотой” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай” гэж, 59 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн өмчийн хорооноос” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас” гэж, 21 дүгээр зүйлийн 15 дахь хэсгийн “байдалд, Төрийн өмчийн хороо нь тухайн хуулийн этгээдийн” гэснийг “байдал,” гэж, 54 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Төрийн өмчийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж, 65 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн өмчийн хорооны хуралдаанаар хэлэлцэж” гэснийг “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 66 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “дүнг хамтран хэлэлцэж” гэснийг “дүнгийн мөрөөр” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчийн хороо,” гэснийг, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчийн хорооны болон” гэснийг, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Төрийн өмчийн хороотой хамтран” гэснийг тус тус хассугай.



4 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 21¹ дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 60.3.5 дахь заалт нэмсүгэй:

“60.3.5.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд гарал үүслийг нотлох баримт бичиг.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2015 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.10 дахь хэсэг нэмсүгэй:

“4.10.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу импортын бараанд гаалийн хөнгөлөлттэй тариф хэрэглэнэ.”

2 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“4.2.Импортын барааны гаалийн тарифыг ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тариф гэж ангилах бөгөөд ердийн тариф нэн тааламжтай тарифаас хоёр дахин их байна. Хөнгөлөлттэй тарифыг олон улсын гэрээгээр тогтооно.”

3 дугаар зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.2 дахь заалтын “хөнгөлөлттэй тариф хэрэглэхээр” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

**Монгол Улсын 2016 оны төсвийн тухай
хууль баталсантай холбогдуулан авах
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.17 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хасагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээнээс нэг маягийн зураг төслөөр барьж болох, 320 хүртэлх суудалтай сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилгыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт тусган ажиллах;

2/Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан, урьдчилсан



гүйцэтгэл нь 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 80-н хувиас дээш гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж байгаа боловч санхүүжилтийг нь бүрэн олгож чадаагүй төсөл, арга хэмжээний болон 2015 онд “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр ажил нь бүрэн дууссан төслийн санхүүжилтийг тус тус 2016 онд векселиэр санхүүжүүлэх арга хэмжээг авч, төлбөрийг Монгол Улсын 2017 оны төсвийн төсөлд тусгах;

3/эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох;

4/төсвийн зардлыг бүх шатанд хэмнэж, бууруулахтай холбогдуулан 2016 оны төсвийн жилд өр авлага үүсгэхгүй байх, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор батлагдсан урсгал зардлыг төсвийн ангилал хооронд хуульд зааснаар зохицуулалт хийж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрөх;

5/нийслэл болон орон нутагт төрийн албан хаагчдын тоо, төрийн байгууллагуудын конторын барилга нэмэгдсэнээс урсгал зардал өсч байгаад дүгнэлт хийж, төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын байршлыг оновчтой тогтоох, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, орон тоо болон конторын барилгын тоог бууруулж, байр ашиглалтын зардлыг хэмнэх;

6/үйлчилгээний орлогоороо өөрийгөө санхүүжүүлэх боломжтой боловч төсвөөс санхүүждэг байгууллагуудыг аж ахуйн тооцоонд үе шаттайгаар шилжүүлэх, зөвхөн төр үйлчилгээг нь худалдан авсан тохиолдолд төсвөөс санхүүждэг байхаар зохион байгуулах;

7/Хууль зүйн сайдын багц дахь Мөрдөн байцаах албаны конторын барилгын концессын асуудлыг шийдвэрлэж, уг барилгыг Улсын нэгдүгээр эмнэлгийн амбулаторын зориулалттай барилга болгож, дуусгах хөрөнгийг шийдвэрлэх талаар санал боловсруулах;



8/“Нэг эмнэлэг-хоёр жигүүр” концессын төслийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэх;

9/Зам тээврийн сайдын багцын авто замын төсөвт өртгийг өөрчлөх, нэмэгдүүлэх шаардлагын талаар тусгайлан судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналаа боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

10/цалин, тэтгэврийг нэмэгдүүлэхтэй холбогдсон Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2015-2016 оны Улсын нэмэлт хэлэлцээрийн 3.4 дэх заалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2016 оны төсвийн тодотголын төсөлд тусгах боломжийг судалж, санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах;

11/малчдын амьжиргааны түвшинг сайжруулах, махны зах зээл, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд “Мах” хөтөлбөрийг боловсруулан, Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

12/2016 оны хаврын тариалалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тариалалтад зориулсан зээлийн эх үүсвэрийг холбогдох хуулийн хүрээнд Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

13/эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулахын тулд бүрэн хэрэгжих үндэслэл бүхий тусгай дэд хөтөлбөрүүдийг боловсруулж, шаардлагатай тохиолдолд Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хурлаар холбогдох шийдвэрийг гаргуулах;

14/батлагдсан төсвөө хэтрүүлсэн, бүтэц, орон тоог үндэслэлгүй нэмэгдүүлсэн бүх шатны төсвийн захирагчид Төсвийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Ч.Улаан/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



Монгол Улсын Их Хурлын 2015 оны
108 дугаар тогтоолын хавсралт

**НЭГ МАЯГИЙН ЗУРАГ ТӨСЛӨӨР 2016 ОНД
КОНЦЕССООР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ**

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил
1	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Буянт-Ухаа-1” хороололд цэцэрлэгийн барилга худалдаж авах /Улаанбаатар, Хан-уул дүүрэг/
2	Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Буянт-Ухаа-2” хорооллын цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Хан-уул дүүрэг/
3	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо/
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дундговь, Сайнцагаан сум/
5	Сургуулийн барилга, 320 суудал, спорт заалын хамт /Архангай, Цахир сум/
6	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 26 дугаар хороо/
7	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 29 дүгээр хороо/
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Баянтүмэн сум/
9	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 24 дүгээр хороо/
10	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Цагаан-Уул сум/
11	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/
12	Цэцэрлэгийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/
13	Цэцэрлэгийн барилга, 180 ор /Ховд, Жаргалант, 1 дүгээр цэцэрлэг/
14	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Баянхонгор, 6 суманд/
15	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 3 дугаар баг "Салхит"/



16	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Хөвсгөл, Жаргалант сум/
17	Сургуулийн дотуур байрын барилга, 150 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум/
18	Цэцэрлэгийн барилга /Хэнтий, Цэнхэрмандал сум/
19	Цэцэрлэг, сургууль, соёлын төвийн цогцолбор /Увс, Зүүнговь сум/
20	Сургуулийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Мандал сум, 3 дугаар сургууль/
21	Сургуулийн дотуур байрын барилга /Өмнөговь, Хүрмэн сум/
22	Сургуулийн дотуур байрын барилга, 150 ор /Баян-Өлгий, Дэлүүн сум/
23	Сургуулийн барилга, 320 суудал /Хөвсгөл, Цагаан-Уул сум/
24	Цэцэрлэгийн барилга худалдаж авах, 120 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/
25	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор сургуулийн хашаанд/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны 12 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 15 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Шүүх барьцааны зүйлийг худалдах тухай үүрэг гүйцэтгүүлэгчийн нэхэмжлэлийг хангасан, эсхүл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.1-д заасны дагуу нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулсан шүүгчийн захирамж гарсан бол уг зүйлийг Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу албадан дуудлага худалдаагаар худалдана.” гэж заасны “... , эсхүл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.1-д



заасны дагуу нотариатын мэдэгдэх хуудсыг баталгаажуулсан шүүгчийн захирамж гарсан ..." гэсэн хэсэг; 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэгт "Газар барьцаалах гэрээнд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184.1-д заасан журмаар гаргуулахаар талууд харилцан тохиролцож болно.", мөн зүйлийн 53.5 дахь хэсэгт "Энэ хуулийн 53.4-т заасан гэрээг нотариатаар гэрчлүүлнэ." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "... шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй.", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 15 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2015 оны 12 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2-т заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн тул Өкейн Саулег Баян-өлгий, Увс, Ховд аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Гаажидын Дэлгэрбямбыг Өмнөговь, Дундговь, Төв аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Тогтохын Алтанчимэг, Тогтоолын Байгонак нарыг Увс аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 432

Улаанбаатар
хот

Гадаадаас 2016 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4, 7.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад 2016 онд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заагаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь байхаар тогтоосугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо нь энэхүү тогтоолын хавсралтаар баталсан хувиас илүү гарсан нөхцөлд 50 хүртэлх гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн авах бол салбарын сайдын хүрээнд, 50-аас дээш бол Засгийн газарт асуудлыг тавьж шийдвэрлүүлж байхыг Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханд үүрэг болгосугай.

4. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах арга хэмжээ авахыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Г.БАЯРСАЙХАН

Засгийн газрын 2015 оны 432 дугаар
тогтоолын хавсралт

2016 ОНД АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НИЙТ МОНГОЛ АЖИЛЛАГЧДЫН
ТООНД ЭЗЛЭХ ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ХУВЬ

Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Үйл ажиллагааны салбарын ангилал	Нийт ажиллагчдын тоо				
					15-30	31-50	51-100	101-200	201- түүнээс дээш
					Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь				
В				УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ					
	06	061	0610	Газрын тос, байгалийн хийн олборлолт	10	20	60	70	70
				Газрын тос, байгалийн хийн хайгуул	10	20	60	70	70
	09	099	0990	Уул уурхайн олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	10	20	20	25	25
С				БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР					
	10			Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	5	5	5	5
	13			Нэхмэлийн үйлдвэрлэл	15	15	15	15	15
	20			Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	15	15	15	15	15



23		Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	15	15	15	15	15	15	15
24		Металл үйлдвэрлэл	15	15	15	15	15	15	15
32		Бусад боловсруулах үйлдвэрлэл	15	15	15	15	15	15	15
33		Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар үйлчилгээ	10	15	20	25	25	25	25
D		ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ	10	10	10	10	10	10	10
E		УС ХАНГАМЖ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	10	10	10	10	10	10	10
F		БАРИЛГА							
41	410	Барилга угсралт	10	15	15	20	20	25	25
		Үйлдвэрийн болон уул уурхайн барилга угсралт	10	20	25	30	30	35	35
	421	Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	10	20	25	30	30	45	45
G		БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ							
	45	Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	10	10	10	10	10	10	10

Н				ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	25	25	25	25	25	25
I				ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ						
	55			Зочид буудал, байр сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	15	15	15	15	15	15
	56			Нийтийн хоолны үйлчилгээ	10	10	10	10	10	10
M				МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА						
	72			Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа	30	30	30	30	30	30
N				УДИРДЛАГЫН БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА						
		791		Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын үйл ажиллагаа	10	15	20	20	20	20
P	85			БОЛОВСРОЛ						
		851, 852, 854		Бага болон бүрэн дунд, бусад боловсрол олгох үйл ажиллагаа	40	40	40	40	40	40
		853, 8522, 8530		Техник мэргэжлийн дунд боловсрол болон дээд боловсрол олгох үйл ажиллагаа	30	30	30	30	30	30
Q				ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БА НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА						
		86		Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа	10	10	15	15	15	15
		87		Оршин суугчдад үзүүлэх халамжийн үйл ажиллагаа	10	10	15	15	15	15

R				УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ								
90	900	9000		Бүтээл туурвих, урлаг, үзвэр, үйлчилгээний үйл ажиллагаа	10	10	10	10	10	10	10	10
93				Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа	10	10	10	10	10	10	10	10
S				ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА								
95				Хувийн болон өрхийн хэрэглээний зориулалттай бараа, компьютерийн засвар үйлчилгээ	10	10	10	15	15	15	15	15
96	960			Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10	10	10	15	15	15	15	15
U				ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА								
99	990	9900		Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	40	40	40	40	40	40	40	40

Жич: 1. 15 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага нь 1 гадаадын иргэн ажиллуулж болно.

2. Гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын төрийн бус байгууллагад нийт ажиллагчдын 30 хүртэл хувьд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулж болно.

3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээдийн удирдах бүрэлдэхүүний 3 төлөөлөгч, гадаадын хөрөнгө оруулагч 1 хувь хүнийг хөрөнгө оруулалтын



асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг үндэслэн энэ тогтоолд заасан хувь, хэмжээнд хамааруулалгүй хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгож болно.

4. Засгийн газар хоорондын гэрээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай, олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулдаг боловсролын байгууллагад нийт ажиллагчдын 80 хүртэл хувьд гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 441

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 7.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийн “Төрийн захиргааны байгууллагын албан тушаал” гэсэн хэсгийн ТЗ-8 зэрэглэлд “4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч” гэж, “Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал” гэсэн хэсгийн ТЗ-7 зэрэглэлд “11. Нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогч” гэж, мөн хэсгийн ТЗ-6 зэрэглэлд “11. Аймаг, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогч” гэж, мөн хэсгийн ТЗ-5 зэрэглэлд “10. Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч” гэж тус тус нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ч.САЙХАНБИЛЭГ

ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Г.БАЯРСАЙХАН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1

Индекс: 14003